ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
Магадлалын ерөнхий дүгнэлтийн
дугаар 408/2024
МАГАДЛАЛ ХИЙГДСЭН
Магадлал хариуцсан
Хэлтсийн дарга......../гарын үсэг/
2024 оны 09 сарын ... өдөр

"ДАВАА ЗАМ" ХХК

ЕГ Шифр: - 03/2024

Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 11 дүгээр хороо

# 129-Р СУРГУУЛЬ ХҮРТЭЛХ АВТО ЗАМЫН ШИНЭЧЛЭЛТ

(ажлын зураг)

АВТО ЗАМ - А3

Захирал .................................................... / Э.Бат-Эрдэнэ /

Инженер .................................................... / Ж.Даваасүрэн /

Улаанбаатар хот
2024 он

ЗӨВШИЛЦСӨН:
НЗХГ-ын Бодлогын төлөвлөлтийн хэлтсийн дарга ........................ /Б.Мягмар/
НЗХГ-ын БТХ-ийн ахлах мэргэжилтэн. ........................ /Б.Анхбаяр/
НЗХГ-ын БТХ-ийн төлөвлөлтийн мэргэжилтэн. . ........................ /

ҮНДЭСЛЭЛ:
-Нийслэлийн Засаг даргын 202... оны ...-р сарын ...-ны өдрийн А/......-р "Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай" захирамж
-Захиалагчийн Зөвлөхтэй байгуулсан зураг төсөл боловсруулах ажлын гэрээ -Зураг төсөл боловсруулах ажлын даалгавар

| Д/Д | ТОДОРХОЙЛОЛТ | ТАЙЛБАР |
|---|---|---|
| 1 | Шинэчилж буй авто зам | Төлөвлөж буй |
| 2 | Хувьсгалчдын гудамж зам | Төлөвлөж буй |
| 3 | Уулын оройн зам | Одоо байгаа |
| 4 | Ерөнхий боловсролын 129-р сургууль | Одоо байгаа |
| 5 | Сүхбаатарын талбай | Одоо байгаа |

## ХЭСЭГЧИЛСЭН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ М1:500




## БАЙРШЛЫН СХЕМ 1:10000




### ТАНИХ ТЭМДЭГЛЭГЭЭ

- Төлөвлөж буй барилга
- Төлөвлөж буй авто зам
- Төлөвлөж буй явган хүний зам
- Төлөвлөж буй хөтөч хавтан
- Төлөвлөж буй ногоон байгууламж
- Архитектур төлөвлөлтийн даалгаврын схемийн хил хязгаар
- Эзэмшил газрын хил хязгаар
- Одоо байгаа барилга
- Одоо байгаа нураах барилга байгууламж
- Одоо байгаа явган хүний зам
- Одоо байгаа орон нутгийн чанартай авто зам
- Бохир усны шугам
- Дулааны шугам
- Цэвэр усны шугам
- Цахилгааны шугам

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| "ДАВАА ЗАМ"ХХК | УБ, СХД, 11-р хороо, 129-р сургууль хүртэлх авто замын шинэчлэлт | | | | А3 |
| | Захирал | Б.Бат-Эрдэнэ | Бат-Эрдэнэ | Байршлын тойм зураг | МАСШТАБ: 1:500 |
| | Зур.инж | Ж.Даваасүрэн | | | Үе шат / Хуудас / Бүх хуудас |
| | Гүйцэтгэсэн | Ж.Даваасүрэн | | ЕГ шифр: 03 / 2024 | А3 / 1 / 1 |
| | Шалгасан | Б.Бат-Эрдэнэ | Бат-Эрдэнэ | ТГ шифр: | 2024.05 |

А3

ЗӨВШИЛЦСӨН:
НЗХГ-ын Бодлогын төлөвлөлтийн хэлтсийн дарга . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . /Б.Мягмар/
НЗХГ-ын БТХ-ийн ахлах мэргэжилтэн. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . /Б.Анхбаяр/
НЗХГ-ын БТХ-ийн төлөвлөлтийн мэргэжилтэн. . . . . . . . . . . . . . . /................../

ҮНДЭСЛЭЛ:
-Нийслэлийн Засаг даргын 2023 оны 10-р сарын 23-ны өдрийн А/1241-р "Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай" захирамж
-Захиалагчийн Зөвлөхтэй байгуулсан зураг төсөл боловсруулах ажлын гэрээ -Зураг төсөл боловсруулах ажлын даалгавар

| Д/Д | ТОДОРХОЙЛОЛТ | ТАЙЛБАР |
|---|---|---|
| 1 | Төлөвлөж буй авто зам | Төлөвлөж буй |
| 3 | ЧД-ийн хөрөнгө оруулалтын баригдах зам | Төлөвлөж буй |
| 4 | Цэцэрлэг | Одоо байгаа |
| 5 | Ерөнхий боловсролын 149-р сургууль | Одоо байгаа |
| 6 | Гадна тойруугийн авто зам | Одоо байгаа |

## ХЭСЭГЧИЛСЭН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ M1:500



## БАЙРШЛЫН СХЕМ 1:10000




## ТАНИХ ТЭМДЭГЛЭГЭЭ

- Төлөвлөж буй барилга
- Төлөвлөж буй авто зам
- Төлөвлөж буй явган хүний зам
- Төлөвлөж буй хөтөч хавтан
- Төлөвлөж буй ногоон байгууламж
- Архитектур төлөвлөлтийн даалгаврын схемийн хил хязгаар
- Эзэмшил газрын хил хязгаар
- Одоо байгаа барилга
- Одоо байгаа нураах барилга байгууламж
- Одоо байгаа явган хүний зам
- Одоо байгаа орон нутгийн чанартай авто зам
- Бохир усны шугам
- Дулааны шугам
- Цэвэр усны шугам
- Цахилгааны шугам

| | | | | |
|---|---|---|---|---|
| "ДАВАА ЗАМ"ХХК | УБ, СХД, 11-р хороо, 129-р сургуулийн авто зам, /үргэлжлэл/ -ийн зураг төсөл | | | А3 |
| | Захирал | Б.Бат-Эрдэнэ | Байршлын тойм зураг | МАСШТАБ: 1:500 |
| | Зур.инж | Ж.Даваасүрэн | | Үе шат: А3 / Хуудас: 1 / Бүх хуудас: 8 |
| | Гүйцэтгэсэн | Ж.Даваасүрэн | ЕГ шифр: 04 / 2024 | |
| | Шалгасан | Б.Бат-Эрдэнэ | ТГ шифр: | 2024.04 |

А3

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|

# УБ, СХД, 11-р хороо, 129-р сургууль хүртэлх авто замын шинэчлэлт

ХЭСЭГЧИЛСЭН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ М1:500




ЗӨВШИЛЦСӨН.

НИЙСЛЭЛИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЛБАНЫ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

. . . . . . . . . . . . . . . . . . . ./Г.МӨНХБААТАР/

2024.09.10.

НЗХГ-ЫН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

. . . . . . . . . . . . . . . . . . . ./В.МЯГМАР/

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН ТӨВИЙН ДАРГА

. . . . . . . . . . . . . . . . . . . ./Ч.ХУВЬЗАЯА/

"МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ" ХХК-ийн ТУ, Төлөвлөлтийн газар, дэд бүтэц, төлөвлөлтийн хэлтсийн дарга

. . . . . . . . . . . . . . . . . . . ./С.ЗОЛЖАРГАЛ/

"УБЦТС" ТӨХК -ИЙН ТЕХНИКИЙН АСУУДАЛ ЭРХЭЛС ДЭД ЗАХИРАЛ

. . . . . . . . . . . . . . . . . . . ./Л.ГАН

НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГА

. . . . . . . . . . . . . . . . . . . ./Д.ОТГОНЖАРГАЛ/

"УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ" ТӨХК-ИЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

. . . . . . . . . . . . . . . . . . . ./Ш.МӨНХЖАРГАЛ/

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗРЫН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

. . . . . . . . . . . . . . . . . . . ./Ж.ДАГВАСҮРЭН/

ГЕОДЕЗИ, УСНЫ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ГАЗРЫН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

. . . . . . . . . . . . . . . . . . . ./С.БАТСАЙХАН/

"ДАВАА ЗАМ" ХХК -ИЙН ЗАХИРАЛ

. . . . . . . . . . . . . . . . . . . ./Б.БАТ-ЭРДЭНЭ/

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| УБ, СХД, 11-р хороо, 129-р сургуулийн авто зам, /үргэлжлэл/ -ийн зураг төсөл | | | | А3 | | |
| Захирал | Б.Бат-Эрдэнэ | Бат-Эрдэнэ | Зөвшилцлийн нүүр хуудас | МАСШТАБ: 1:500 | | |
| Зур.инж | Ж.Даваасүрэн | | | Үе шат | Хуудас | Бүх хуудас |
| Гүйцэтгэсэн | Ж.Даваасүрэн | | ЕГ шифр: 03 / 2024 | А3 | 2 | 8 |
| Шалгасан | Б.Бат-Эрдэнэ | Бат-Эрдэнэ | ТГ шифр: | 2024.0200 | | |

"ДАВАА ЗАМ"ХХК

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | А3 |
|---|---|---|---|---|---|---|---|---|

# 1. ОРШИЛ

## 1.1 Үндэслэл

- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52-р тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
- Монгол Улсын Их Хурлын 2021 оны 105-р тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”
- Монгол Улсын Их Хурлын 2013 оны 23-р тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг;
- Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
- Нийслэлийн Засаг даргын 2024 оны 07-р сарын 08-ны өдрийн А/842-р захирамж;
- Захиалагчийн Зөвлөхтэй байгуулсан зураг төсөл боловсруулах ажлын гэрээ;
- Зураг төсөл боловсруулах ажлын даалгавар;
- “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” БНбД 30.01.04 болон “Авто зам төсөллөх” ЗЗБНбД 22-04-2016;
- “Эрхт газар” ХХК-ний боловсруулсан инженер-геодезийн хайгуул судалгаа;
- “Жи Ар Си” ХХК-ийн боловсруулсан “УБ хот, СХД, 11-р хороо, Төв замаас 129-р сургууль хүртэлх Хувьсгалчдын гудамж чиглэлийн 1 км авто зам, Төв замаас 28-р хороо хүртэлх 0.9км авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл”

## 1.2. Ажлын бүтэц, бүрэлдэхүүн

### 1.2.1. Зураг төслийн ажлын бүрэлдэхүүн

Авто замын ажлын зураг, төсөв. Дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

- ЕБ-ын 129-р сургуулийн шинээр хийгдэж буй зогсоолын дэргэдээс үргэлжлүүлэн гүвээн дээрх замтай нийлүүлэх L=160 м зам.
- Шинэ замын инженер-геодезийн хайгуул, судалгаа
- Зам барилгын ажилд тавигдах техникийн шаардлага

Жин: Энэ хэсэгт өмнө 2018 онд баригдсан буй трассад өөрчлөлтийг одоо гарч байгаа хүндрэл болох хэт их өгсүүр, өвөл цас мөсөөр хучигдсан байхад ЗТО их гардаг, хөдөлгөөний аюулгүй байдал хангагдахгүй байгаа нөхцөл байдлыг өөрчлөх шаардлагын дагуу тус хорootой зөвшилцөн трассыг өөрчлөв.

Мөн нэмж дурдахад 11-р хорооны дарга, 129-р сургуулийн талаас , иргэд олон нийтийг төлөөлж удаа дараа хүсэлт гаргасан дагуу тус арга хэмжээ авагдаж байна.

### 1.2.2. Зам барилгын ажлын бүрэлдэхүүн

Тус төслийн хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Шинээр 157.75 м гудамж зам барих. Газар чөлөөлөлттэй.
- Ухмалтай хэсэгт тулц хана цутгана. Эсхүл лего блок өрнө.
- Явган замыг шинээр барих.

## 1.3. Төслийн танилцуулга

- Төслийн нэр: ЕБ-ын 129-р сургуулийн замын үргэлжлэл
- Байршил: СХД-ийн 11-р хороо
- Зөвлөх компани: “Даваа зам” ХХК
- Шинэчлэлтийн зураг, төсөв боловсруулахад оролцсон компаниуд. Үүнд:
  - Байр зүйн зураглал: “Эрхт газар” ХХК

## 1.4. Төслийн захиалагч

- Нийслэлийн Замын хөгжлийн газар

## 1.5. Техникийн үзүүлэлтүүд

### 1.5.1. Техникийн үзүүлэлтүүд

| № | Замын параметрууд | Х/нэгж | Шинэ хэсэг |
|---|---|---|---|
| 1 | Замын урт | м | 157.65 |
| 2 | Эргэлтийн тоо | шир. | 4 |
| 3 | Эргэлтийн муруйн Rmin | м | 12.0 |
| 4 | Эргэлтийн муруйн Rmax | м | 30.0 |
| 5 | Эргэлт.муруйн нийт урт | м | 55.70 |
| 6 | Муруйн хэсгийн трассад эзлэх хувь | % | 35.29 |
| 7 | Бос. гүдгэр муруйн Rmin | м | 705.0 |
| 8 | Бос.гүдгэр муруйн Rmax | м | 705.0 |
| 9 | Босол хотгор муруйн Rmin | м | - |
| 10 | Босоо хотгор муруйн Rmax | м | - |
| 11 | Дагуу налуун Imin | ‰ | 52.0 |
| 12 | Дагуу налуун Imax | ‰ | 120.0 |
| 13 | Дагуу налуун Imax бүхий хэсгийн урт | м | 41.7 |
| 14 | Замын өргөн | м | 10.60 / 13.60 |
| 15 | Зорчих хэсгийн өргөн | м | 6.0 / 6.5 |
| 16 | Хөвөөний өргөн | м | 0.5 |
| 17 | Явган зам | м | 1.75 |
| 18 | Дугуйн зам | м | Явган замын 0.75 м |
| 19 | Ногоон зурвас | м | 0.5 |
| 20 | Хучлагын төрөл | - | Шилжилт |
| 21 | Хучилтын төрөл | - | Байгалийн чулуу/АБ |

### 1.5.2. Муруйн цэс

А. Замын шинэ хэсгийн муруйн цэс

| Цэг | Өнцгийн орой | | | Координат | | Элементүүдийн нэр | | Радиус, м | Эргэлтийн элемент, м | | | | | | | Шилжилтийн муруйн байршил | | | | | | | | Өнцгийн оройн хоорондох зай, м | Шулууны урт, м |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | | | эхлэл | | төгсгөл | | эхлэл | | төгсгөл | | | |
| | км | пк | + | X | Y | зүүн | баруун | | тангенс | тангенс | Шилжилтийн муруй | | тойрог эргэлт | биссектрис | домер | пк | + | пк | + | пк | + | пк | + | | |
| 3Э | 0 | 1 | 85.000 | 5311860.643 | 638781.104 | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | 66.33 | 43.82 |
| ӨО2 | 0 | 2 | 51.331 | 5311802.553 | 638813.125 | | 112° 58' 18" | 15.00 | 22.51 | 22.51 | 0.00 | 0.00 | 29.49 | 12.05 | 15.53 | 2 | 28.823 | 2 | 28.823 | 2 | 58.312 | 2 | 58.312 | | |
| | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | 39.03 | 14.43 |
| ӨО3 | 0 | 2 | 74.832 | 5311798.320 | 638774.327 | 7° 59' 16" | | 30.00 | 2.09 | 2.09 | 0.00 | 0.00 | 4.18 | 0.07 | 0.01 | 2 | 72.738 | 2 | 72.738 | 2 | 76.920 | 2 | 76.920 | | |
| | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | 7.77 | 3.28 |
| ӨО4 | 0 | 2 | 82.594 | 5311796.412 | 638766.797 | | 9° 07' 29" | 30.00 | 2.39 | 2.39 | 0.00 | 0.00 | 4.78 | 0.10 | 0.01 | 2 | 80.200 | 2 | 80.200 | 2 | 84.977 | 2 | 84.977 | | |
| | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | 33.62 | 20.73 |
| ӨО5 | 0 | 3 | 16.202 | 5311793.430 | 638733.311 | 82° 21' 36" | | 12.00 | 10.50 | 10.50 | 0.00 | 0.00 | 17.25 | 3.94 | 3.75 | 3 | 5.704 | 3 | 5.704 | 3 | 22.953 | 3 | 22.953 | | |
| | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | 30.20 | 19.70 |
| 3Т | 0 | 3 | 42.654 | 5311763.262 | 638731.967 | | | | | | | | | | | | | | | | | | | | |

Тайлбар: Замын урт **L=157.654 м**

Зураг 1. Замын шинэчлэх гэж буй хэсэг ба тухайн хэсгийн з төлөв байдал




Нөхцөл байдал:

- Хайрган замын төгсгөлөөс эхлэн улмаар уулын оройгоор явж буй замтай нийлэх хүртэл буюу тус замын төгсгөл хүртэл хэсэг нь одоо хучилтгүй. Дагуу налуугийн хэмжээ 122-152 промилийн налуутай байна.
- Сургуулийн орчин тоосжилт маш ихтэй.
- ЕБ 129-р сургууль нь зогсоолтой болж байгаа. Хөрөнгө оруулалт тавигдсан. Тус зогсоол хүртэл хамгийн багадаа хатуу хучилттай болох хүсэлтэй.
- Явган замын хайс гэмтсэн байдалтай.
- Явган замын нөхцөл байдал харьцангуй сайн.

## 2. ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН СУДАЛГАА, ДҮГНЭЛТ

Шаардлагагүй. Өмнөх зураг төсөлд бий.

## 3. ЗАМЫН ЗУРАГ ТӨСЛИЙН ГЕОДЕЗИ, БАЙР ЗҮЙН ЗУРАГЛАЛ

Тус замын байршил ба өндрийн үндэслэлийг **"Эрхт газар" ХХК** 2024 оны 5-р сард гүйцэтгэсэн. Инженер – геодезийн тайланг үзнэ үү.

## 4. ЗАМ БАРИГДАХ ЗУРВАС ГАЗРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТРАСС БОЛОН ДАГУУ ОГТЛОЛЫН БАЙГУУЛАЛТУУД

Тус замын хучилтгүй, налуу ихтэй үлдсэн хэсгийг 2 дэд хэсэгт хуваасан. Эхний удаад сургуулийн зогсоол хүртэл хатуу хучилттай болгох зорилго тавьж шинэчлэлтийн арга хэмжээ авахаар төлөвлөсөн.

Харин үлдсэн хэсгийг хатуу хучилттай болгохын тулд дагуу налууг хамгийн ихдээ байгалийн чулуу хийж болохуйц байхаар 120 промиль дагуу налуутай болгох шаардлагатай. Үүний тулд замын тухайн хэсгийн трассыг өөрчлөв.

Энэ бүгдийг тооцоод хучилтгүй үлдсэн хэсгийн дараах зураг үзүүлсэнчлэн 2 хэсэгт хуваав.

Зураг 2. Гооглийн хиймэл дагуулын зураг дээрх байршлын тойм зураг



Жич: Улаан шугамаар эхний удаад шинэчлэлт хийгдсэн хэсгийг үзүүлэв. Харин үлдсэн 157.654 м хэсгийг хөх шугамаар тус зурагт үзүүлэв.

Зураг 3. Баригдах гэж буй зогсоол болон хучилтгүй 2 хэсгийн төлөвлөлт



Тухайн замын нөхцөл байдлын талаар фото зургуудын доор тайлбар оруулах замаар өгсөн.

## 5. ЗОГСООЛ

Налуу ихтэй тул дунд хэрд 8 м урттай кармаан хийсэн байгааг хэвээр үлдээв. Энэ нь хөдөлгөөний аюулгүй байдалд зэрэг нөлөө үзүүлж байгааг тэмдэглэв байна. Тус тайлбар өмнөх хэсгийн зурагт хамаарна.

## 6. ХӨНДЛӨН ОГТЛОЛЫН ТӨЛӨВЛӨЛТ

Зурвас газрын өргөн хангалтгүй, газар чөлөөлөлт бага байлгах, мөн гудамж замыг явган зорчигчид болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй буюу хүртээмжтэй төсөллөлтийг хангасан байх, тухайн гудамж замыг ногоон байгууламжтай байлгах зорилгын үүднээс хөндлөн огтлолын элементүүдийг тооцсон. Зураг 7-г үзэх.

Ажлын зургаас нэг маягийн хөндлөн огтлолуудыг нарийвчлан үзнэ үү. Нийт 2 төрлийн хөндлөн огтлол бий. Ерөнхийдөө эхлэл хэсгийн гүн ухмалтай хэсэгт налуу ихтэй буюу байгалийн чулуун хучилттай хэсэг таарч байгаа болно.

### Хучилт

Зорчих хэсэг болон явган хүний замын хучилтыг асфальтбетон хучилттай төлөвлөсөн. Гэхдээ 80 промилиэс илүү их налуутай доорх байршилд байгалийн чулуун хучилтыг төлөвлөсөн. Үүнд:

- ПК1+85.0 - ПК2+55.0 буюу L=70 м урт хэсэгт байгалийн чулуун хучилт хийнэ.
- Замын бусад хэсэгт асфальтбетон хучилт төлөвлөсөн.

Зураг 4. Нэг маягийн хөндлөн огтлол /хагас ухмал, хагас далан төрөл/




Явган замын хучилтыг асфальтбетон хучилттай төлөвлөсөн.

Уулын гүвээ рүү өгссөн налуу эгц хэсэг учраас замын налууд баригдаж ухмал бараг нийт уртад гарав. Нөгөө талаас айлын өмчилсөн газар байгаа учраас ухмалын гадна налууг хангалттай дэлгэх боломжгүй тул лего блокоор тулц хана барихаар тооцов.

Зураг 5. Лего блокон тулц хана



Тайлбар: Тулц ханыг лего блокоор хийх хамгийн өндөр нь хөндлөн огтлолоос үзвэл ПК2+42.5 байршилд уулан талд ажлын өндөр 2.751 байна. Ерөнхийдөө блокон тулц ханыг газраас 2.0 м-ээс илүүгүй байлгах буюу 4-н үер байх болно гэж тооцов. Зарим хэсэгт ухагдаж сууна гэж үзэв. Хамгийн нам тул ханыг 1 үе буюу 0.5 м өндөртэй байна гэж үзэв. Ингээд тооцвол тулц хана нь замын зүүн гарын талд бол **L1= 125 м урт /185-310 хооронд/**, харин баруун гар талд буюу нам талд **L2=75 м урт /185-260 хооронд/** тус тус өрөгдөнө. **Нийт урт 200 м** болно.

Блок үйлдвэрлэл: Жишээ болгож Боржигон хийц компанийн холбоосыг доор тавив. Тус компаний 40 см өргөн блокоор 4-р хороололд Модны 2-н замыг өргөтгөхөд түшиц хана хийж байсан практик байна.

https://www.facebook.com/profile.php?id=100083422865028&sk=photos

*Хэмжээ, үнийн санал*

*В40: 160x40x60 147,000 НӨАТ-тай 131,000 НӨАТ-гүй*

*В30: 180x30x60 132,000 НӨАТ-тай 120,000 НӨАТ-гүй*

*Та дэлгэрэнгүй мэдээлэл зөвлөгөөг 9994-7575, 8966-6498, 9969-3669 дугаараас аваарай.*

## 7. ДАГУУ ОГТЛОЛЫН ТӨЛӨВЛӨЛТ

Хучилтын хийцийг дагуу огтлолын налуугаас хамааруулж авав. Өөрөөр хэлбэл асфальтбетон хучилтыг 80 промилиэс бага налуутай хэсэгт, харин 120 промиль бүхий бусад хэсгүүдэд байгалийн чулуун хучилт төсөллөхөөр тооцов.

## 8. УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖ

### 8.1. Зорчих хэсгийн ус зайлуулалт

Налуу ихтэй зам учраас зорчих хэсэгт буусан усыг L хашлагаар зайлуулахаар тооцов.

## ХАВСРАЛТ I: Батлагдсан зургийн даалгавар /шинэ/

БАТЛАВ:
НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.БАЯРСАЙХАН

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

Дугаар: 24/01/0/09

| | | |
|---|---|---|
| 1 | Зураг төсөл боловсруулах үндэслэл | - Нийслэлийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/842 дугаар захирамж |
| 2 | Байршил | СХД, 129 дүгээр сургуулийн авто замын үргэлжлэл |
| 3 | Хөрөнгө оруулалтын эх үүсвэр | "Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт"-ын "1"-д заасан "Авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлт, зураг төсвийн ажил (Улаанбаатар хот)"-ын хөрөнгө |
| 4 | Авто замын техникийн ангилал, замын зэрэг | Төслөөр |
| 5 | Газрын бартаалаг, төвөгшил | Трасс сонголтын үеийн болон замын төсөллөлтийн төвөгшлийг БНбД-ээс харах |
| 6 | Замын хучилтын хийц | Хучилтын бүтээцийг тооцоогоор үндэслэнэ. |
| 7 | Зураг төсөл зохиох үе шат, хугацаа | 1 үе шаттай 2024 он |
| 8 | Зураг төслийн байгууллага | Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байгууллага |
| 9 | Захиалагч байгууллага | Нийслэлийн Замын хөгжлийн газар |
| 10 | Зураг төслийн иж бүрдэл | 1. Инженер геодезийн ажлын тайлан<br>2. Инженер-геологийн судалгааны ажлын тайлан<br>3. Авто зам, замын байгууламжийн ажлын инженерийн нарийвчилсан зураг төсөл<br>4. Тайлбар бичиг (хучилтын тооцоо, ус зүйн тооцоо, ажлын нэр, тоо хэмжээ, авто зам, замын байгууламжийн зураг төслийн бүрдэл, холбогдох захирамж, техникийн нөхцөл, магадлалын дүгнэлт гэх мэт)<br>5. Техникийн шаардлага<br>6. Холбогдох шугам сүлжээний зураг төсөл, төсөв<br>7. Авто зам, замын байгууламжийн нэгдсэн төсөв<br>8. Төслийн танилцуулга |

11. Онцгой нөхцөл:

- Авто замын зургийг Монгол улсад мөрдөж буй "Авто зам төсөллөх" ЗЗБНбД 22-004-2016, "Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ" БД81-104-02, "Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм" БНбД 30.01.04, Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль" БД31.101.04, "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар" MNS 6056-2009, "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, техникийн шаардлага" MNS 5682:2006, "Авто замын гүүр ба хоолой төсөллөх" БНбД 32-02-12, "Явган хүний зам, талбай төсөллөлт, техникийн шаардлага" MNS 6808:2019, , "Авто зам, замын байгууламж. Унадаг дугуйн замыг төлөвлөхөд тавих ерөнхий шаардлага" MNS 5683:2022, "Авто зам, замын байгууламж болон инженерийн шугам сүлжээний ажлын төсөвт өртгийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн жишиг нормын дагуу тооцох, магадлалаар оруулан баталгаажуулах, ЗТХ-ийн Сайдын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 168 дугаар тушаалаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам", Нийслэлийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/456 дугаар захирамжаар баталсан "Нийслэлийн хэмжээнд мөрдүүлэх стандарт, шаардлага" UCS 0901B:2022, UCS 0902B:2022, UCS 0903B:2022 болон бусад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох норм дүрмүүдийг үндэслэх болон бусад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох норм дүрмүүдийг үндэслэх;
- Геодезийн хэмжилт зураглалын ажлыг улсын сүлжээний цэгүүдэд тулгуурлан хийх, зам барилгын суурь бэлтгэл ажлын хүрээнд хийгдэх тулгуур цэг байгуулах, замын төлөвлөлтийн дагуу өндрийн болон байрлалын хэмжилт хийж баталгаажуулж газрын хар өндрийг тодорхойлох;
- Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөө, Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага, Улаанбаатар хотын хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан зураг төслийг боловсруулах;
- Трасс сонголтыг газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт, инженерийн шугам сүлжээ, одоо байгаа барилга байгууламж, хэтийн хөдөлгөөний эрчмийг анхаарч үзэх;
- Гудамж замын төлөвлөлттийн талаар танилцуулга, мэдээллийг тайлбар бичигт тусгах, захиалагч байгууллагад урьдчилан танилцуулах;
- Инженер геологийн судалгаа хийж, хэсэг бүрт хөрсний геотехникийн үзүүлэлтүүдийг нарийвчлан тогтоон замын байгууламжийн бүтээцийг тооцоогоор оновчтой сонгох;
- Хөрсний шинж чанараас шалтгаалан замын суурийг оновчтой сонгох;
- Авто замын үндсэн элементүүд болох авто замын зорчих хэсэг, явган хүний зам, унадаг дугуйн зам /төслөөр/, уулзвар төлөвлөлт, гэрлэн дохио, нийтийн тээвэр болон автомашины зогсоол, явган хүний гарц /төслөөр/, ногоон байгууламж, тусгаарлах зурвас, гадаргуугийн усыг зайлуулах байгууламж болон хөндөгдөж буй шугам сүлжээ зэргийг хамруулан ажлын зургийг иж бүрнээр төсөллөх, план зурагт инженерийн шугам сүлжээний өөрчлөлт газрын нөлөөлөл, орчны мэдээллийг нэгтгэн боловсруулж үзүүлсэн байна;
- Явган хүний зам, ногоон байгууламж, гэрэлтүүлгийн өнгө төрхийг тухайн орчны харагдах нөхцөл байдалтай уялдуулж төлөвлөх;
- Хөндлөн огтлолыг орчны нөхцөлтэй уялдуулан төлөвлөх, барилга байгууламж, айлууд руу орох орц гарцны шийдлийг оновчтой хийж хөндлөн огтлолыг төлөвлөх;
- Гадаргуугийн ус зайлуулалтыг ус хураах талбайн хэмжээнд тооцоо хийж төлөвлөх, ус зайлуулах байгууламжийг цогцоор нь шийдэх;
- Инженерийн шугам сүлжээний байгууллагуудын техникийн нөхцөлийг тусгах, ажлын зураг боловсруулах, холбогдох байгууллагатай зөвшилцөх, ажлын зургийг батлуулах;
- Авто замын төлөвлөлтийг огтлолцож буй болон холбогдож буй бүх талын замын төлөвлөлттэй уялдуулах, авто замын трассын дагууд суваг, шуудуу, жалга дайрсан үед шаардлагатай тохиолдолд гүүр, гүүрэн гарц төлөвлөх;
- Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах замын дагууд тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөн зохицуулалтын тоноглолыг иж бүрэн байдлаар зураг төсөлд тусгах;
- Уулзвар, хөдөлгөөн зохион байгуулалтыг цогц шийдвэрлэх. ЗХУТ-тэй хөдөлгөөн зохион байгуулалтын зургийг зөвшилцөх;

- Авто замын трассад орсон барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд зүйлсийг нарийвчлан гаргаж тайлбар бичигт газар чөлөөлөлтийн талаар тусгайлан оруулах, зургийн шийдлийн дагуу зайлуулах бол тусгах;
- Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчинг бүрдүүлэх зорилгоор зам талбайн болон хөдөлгөөн зохион байгуулалтын арга хэмжээ, тоноглол, замын холбогдох байгууламжуудыг тусгасан байх;
- Авто замын гэрэлтүүлгийг төлөвлөлт хийж, хүчин чадлыг тодорхойлсны дараа тухайн зөвлөх нь "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-иас /өргөдлийн маягт бөглөх/ техникийн нөхцөл авч /эх үүсвэрийг тодруулах/ ажлын зургийг боловсруулах.;
- Авто замын гэрэлтүүлгийг эрчим хүчний хэмнэлттэй, шар тусгалтай чанарын шаардлага хангасан "LED" технологиор шийдвэрлэх;
- Зураг төслийг дараах масштабтайгаар боловсруулна. Үүнд:

| | | |
|---|---|---|
| Дэвсгэр зураг | | 1:500 |
| Дагуу огтлол | хэвтээ | 1:1000 |
| | босоо | 1:100 |
| Хөндлөн огтлол | | 1:100 |
| Уулзвар, огтлолцол | | 1:500 |
| Бүтээц | | 1:20 |

- Авто зам төлөвлөлтийн шатанд буюу авто замын план зургийг Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Замын хөгжлийн газар, Нийслэлийн Газар Зохион Байгуулалтын Албатай тус тус зөвшилцсөний үндсэн дээр нарийвчилсан зураг төсөлд холбогдох газруудаас санал аван зураг төслийг баталгаажуулах.
- Тухайн зам, замын байгууламжийн үндсэн элементүүдийг Нийслэлийн авто замын бүртгэл мэдээллийн сангийн бүтэц бүрэлдэхүүний дагуу мэдээллийг боловсруулж цахим хэлбэрт замын шинж чанарын мэдээллийг үүсгэж "хотын замын мэдээллийн сан"-д оруулах, баталгаажуулах /хавсралтын дагуу боловсруулах/
- Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг Хот байгуулалт, хотын стандартын газрын "ТООН ЗУРГИЙН ТАНИХ ТЭМДЭГ"-ийн дагуу боловсруулсан байна.
- Авто зам, замын байгууламжийн ажлын зураг, тайлбар бичиг, инженер геологийн дүгнэлт, геодезийн хэмжилтийн тайлан, техникийн шаардлага, инженерийн шугам сүлжээний ажлын зураг, орчны тоймыг харуулсан 3D зураг, төслийн танилцуулга бусад холбогдох бичиг баримтыг эх хувь 1ш, хуулбар хувь 2ш (хуулбар хувийг өнгөтөөр хувилж авчрах), тоон хэлбэрээр /DWG болон PDF/ хүлээлгэж өгнө.

**ХЯНАСАН:**

НЗХГ-ын бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга В.Мягмар

НЗХГ-ын Бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Анхбаяр

**БОЛОВСРУУЛСАН:**

НЗХГ-ын бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Ц.Батжаргал

2024 оны..04...сарын..11..-ны өдөр



**ХАВСРАЛТ I: Тухайн замыг барьсан ажлын зураг буюу магадлалаар батлагдсан зургийн нүүр**

ЖИ АР СИ ХХК

МАГАДЛАЛ ХИЙГДСЭН

дугаар 130/2018

Хэлтсийн дарга ........ /гарын үсэг/

20 18 оны 11 сарын 12 өдөр

Шифр:10/17

**УЛААНБААТАР ХОТ, СОНГИНО ХАЙРХАН ДҮҮРЭГ, 11 -Р ХОРОО ТӨВ ЗАМААС 129-Р СУРГУУЛЬ ХҮРТЭЛХ ХУВЬСГАЛЧДЫН ГУДАМЖ ЧИГЛЭЛИЙН 1КМ АВТО ЗАМ, ТӨВ ЗАМААС 28-Р ХОРОО ХҮРТЭЛХ 0,9КМ АВТО ЗАМЫН ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ**



**УЛААНБААТАР ХОТ**
**2017 ОН**

G.R.C

**УЛААНБААТАР ХОТ, СОНГИНО ХАЙРХАН ДҮҮРЭГ, 11 -Р ХОРОО ТӨВ ЗАМААС 129-Р СУРГУУЛЬ ХҮРТЭЛХ ХУВЬСГАЛЧДЫН ГУДАМЖ ЧИГЛЭЛИЙН 1КМ АВТО ЗАМ, ТӨВ ЗАМААС 28-Р ХОРОО ХҮРТЭЛХ 0,9КМ АВТО ЗАМЫН ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ**

**Шифр:10/17**

ЗӨВШИЛЦСӨН:

**НИЙСЛЭЛИЙН ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГАЗРЫН ДАРГА** Э. АНАР




ЗӨВШИЛЦСӨН:

НАЗХГ- ЫН БЗХ-ИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Р.БАТЦОЛМОН

**"УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ" ТӨХК-ийн**

Ерөнхий инженер Б.БАТБАЯР

**"МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ" ТӨК-ийн**

Ахлах инженер Д.БАЛМАА

**"УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР"-ын**

Ерөнхий инженер Ж.ДАГВАСҮРЭН

**"НИЙСЛЭЛИЙН ТЭЭВРИЙН ГАЗАР"-ын**

Орлогч дарга Х.БУЛГАА

**"ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН ТӨВ"-ийн**

Дарга Д.ОДБАЯР

**"НИЙСЛЭЛИЙН ГАЗРЫН АЛБА"-ны**

Дарга Э.БОЛОРЧУЛУУН

БОЛОВСРУУЛСАН:

**"ЖИ АР СИ" ХХК-ийн**

Захирал П.ГАНБОЛД

**ХАВСРАЛТ II: ГУДАМЖ ЗАМЫН ШИНЭЧЛЭХ ХЭСГИЙН ТРАССЫН ПИКЕТАЖИЙН СОЛБИЦОЛ**

| ПК+ | X, м | Y, м | Z, м | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1+85.000 | 5311860.643 | 638781.104 | 1488.361 | |
| 1+90.000 | 5311856.264 | 638783.517 | 1488.972 | |
| 1+95.000 | 5311851.886 | 638785.931 | 1489.583 | |
| 2+00.000 | 5311847.507 | 638788.345 | 1490.193 | |
| 2+05.000 | 5311843.128 | 638790.759 | 1490.804 | |
| 2+10.000 | 5311838.749 | 638793.172 | 1491.415 | |
| 2+15.000 | 5311834.370 | 638795.586 | 1492.026 | |
| 2+20.000 | 5311829.992 | 638798.000 | 1492.637 | |
| 2+25.000 | 5311825.613 | 638800.414 | 1493.247 | |
| 2+28.823 | 5311822.265 | 638802.259 | 1493.711 | Муруйн эхлэл |
| 2+30.000 | 5311821.213 | 638802.786 | 1493.850 | |
| 2+35.000 | 5311816.401 | 638804.060 | 1494.420 | |
| 2+40.000 | 5311811.438 | 638803.688 | 1494.954 | |
| 2+45.000 | 5311806.870 | 638801.714 | 1495.452 | |
| 2+50.000 | 5311803.199 | 638798.353 | 1495.915 | |
| 2+55.000 | 5311800.830 | 638793.976 | 1496.342 | |
| 2+58.312 | 5311800.112 | 638790.750 | 1496.606 | Муруйн төгсгөл |
| 2+60.000 | 5311799.929 | 638789.072 | 1496.735 | |
| 2+65.000 | 5311799.386 | 638784.101 | 1497.091 | |
| 2+70.000 | 5311798.844 | 638779.131 | 1497.412 | |
| 2+72.738 | 5311798.547 | 638776.409 | 1497.573 | Муруйн эхлэл |
| 2+75.000 | 5311798.217 | 638774.172 | 1497.698 | |
| 2+76.920 | 5311797.806 | 638772.297 | 1497.798 | Муруйн төгсгөл |
| 2+80.000 | 5311797.049 | 638769.311 | 1497.958 | |
| 2+80.200 | 5311797.000 | 638769.117 | 1497.969 | Муруйн эхлэл |
| 2+84.977 | 5311796.200 | 638764.412 | 1498.217 | Муруйн төгсгөл |
| 2+85.000 | 5311796.198 | 638764.390 | 1498.218 | |
| 2+90.000 | 5311795.754 | 638759.409 | 1498.477 | |
| 2+95.000 | 5311795.311 | 638754.429 | 1498.737 | |
| 3+00.000 | 5311794.867 | 638749.449 | 1498.996 | |

| ПК+ | X, м | Y, м | Z, м | Комментарий |
|---|---|---|---|---|
| 3+05.000 | 5311794.424 | 638744.469 | 1499.256 | |
| 3+05.704 | 5311794.361 | 638743.767 | 1499.293 | Муруйн эхлэл |
| 3+05.705 | 5311794.361 | 638743.766 | 1499.293 | |
| 3+07.568 | 5311794.053 | 638741.931 | 1499.389 | |
| 3+10.000 | 5311793.230 | 638739.647 | 1499.516 | |
| 3+15.000 | 5311790.206 | 638735.711 | 1499.775 | |
| 3+20.000 | 5311785.847 | 638733.335 | 1500.035 | |
| 3+22.953 | 5311782.943 | 638732.844 | 1500.188 | Муруйн төгсгөл |
| 3+23.837 | 5311782.060 | 638732.805 | 1500.234 | |
| 3+24.368 | 5311781.529 | 638732.781 | 1500.262 | |
| 3+24.369 | 5311781.528 | 638732.781 | 1500.262 | |
| 3+25.000 | 5311780.898 | 638732.753 | 1500.294 | |
| 3+27.141 | 5311778.759 | 638732.658 | 1500.406 | |
| 3+27.671 | 5311778.230 | 638732.634 | 1500.433 | |
| 3+30.000 | 5311775.903 | 638732.530 | 1500.554 | |
| 3+35.000 | 5311770.908 | 638732.308 | 1500.814 | |
| 3+40.000 | 5311765.913 | 638732.085 | 1501.054 | |
| 3+42.654 | 5311763.262 | 638731.967 | 1501.107 | |

## Хавсралт III. ЗАМЫН ШИНЭЧЛЭЛТИЙН АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

Өмнө өгүүлсэнчлэн тус замын шинэчлэлт нь дараах ажлуудаас бүрдэнэ. Үүнд:

1) Зорчих хэсгийн хучилтын шинэчлэлт буюу байгалийн чулуун хучилт барих
2) Явган замын урсгал засвар буюу эвдэрсэн хэсгийн нөхөөс
3) Замын туузан хашлаганы шинэчлэлт буюу эвдэрсэн хэсгийг солих, мөн мөргөсөн байгааг засаж шинээр суулгах
4) Тус гудамж замын эхлэл хэсэг дээрх хоолой дээрх бүтцийн эвдрэлд орсон асфальтбетон хучилтыг төмөрбетон угсармал хучилт болгож шинэчлэн засах. Тус ажилд хоолойн орох ба гарах хэсгийн бетон бэхэлгээ мөн хамаарна.
5) Бэхэлгээтэй шуудуун урсгал засвар болох хог цэвэрлэх, эвдэрсэн бэхэлгээг шинээр цутгах.

**СХД, 13-р хороо, 129-р сургууль хүртэлх авто замын шинэчлэлтийн ажлын тоо хэмжээ**

| № | Зүйл | Хэмжих нэгж | Ажлын тоо хэмжээ | Тайлбар |
|---|---|---|---|---|
| | **1. Талбайн цэвэрлэгээ** | | | |
| 1.01 | Одоо байгаа замын зорчих хэсгийн хайрга /сул шороо/-ыг тэгшлэхийн хамт хусаж авч зайлуулах. | м3 | 456.0 | Програмаас авсан хучилтын тоо хэмжээг үзэх. |
| 1.02 | Хуучин замын зорчих хэсгийн хашлагыг ухаж зайлуулах | м | 336.5 | Дэвсгэр зураг |
| 1.03 | Хуучин явган замын хашлагыг ухаж зайлуулах | м | 91.2 | Програмаас авсан хучилтын тоо хэмжээг үзэх. |
| 1.04 | Явган замыг задалж зайлуулах | м2 | нөхөөс | Нөхөөсний ажлын тоо хэмжээнд орсон |
| 1.05 | Техникийн шаардлагад заасны дагуу хуучин замын тэмдэгийг авч шинэчлэх | ш | 3 | |
| 1.06 | Замын трассыг сэргээх | м | 160.3 | |
| | **2. Хоолой дээрх зорчих хэсгийн завсарын ажил** | | | |
| 2.01 | Эвдэрсэн асфальтбетон хучилтыг задалж авах. Хучилтын зузаан h=7 см. | м2 | 70.0 | 5 м-н урттай хавтангуудыг уртын дагуу 2-г угсарна. Өргөндөө 4-н хавтан буюу нийт 8-н төмөрбетон хавтан байрлуулах талбайг тооцов. |
| 2.02 | Зорчих хэсгийн хашлагыг авч зайлуулах | у/м | 20.00 | 10 м урт хэсэг |
| 2.03 | Явган хүний хашлагыг зайлуулах. | у/м | 20.00 | 11 м урт хэсэг |
| 2.04 | Явган хүний асфальтбетон хучилтыг задалж авах. | м3 | 2 | 1.5*10*0.05*2 |
| 2.05 | Зорчих хэсэг болон явган замын буталсан чулуун суурийг шинэчлэх | м3 | 1053 | 50%-ийг шинэчилнэ гэж тооцов |
| 2.06 | Зорчих хэсгийн 70 м2 талбайд замын төмөрбетон хавтан угсрах. | м3 | 6 | Ухсан траншей дээр бетон цутган үйлдвэрийн түргэн урсгуур суулгана. Бетоны орцыг гарын авлагаас үзэх. |
| 2.07 | Явган зам болон хажуу налууд давуулах далан байдлаар бетон цутгах. h=0.2 м | м3 | 10 | B35 ангийн бетон цутгах. |

| № | Зүйл | Хэмжих нэгж | Ажлын тоо хэмжээ | Тайлбар |
|---|---|---|---|---|
| | **3. Газар шорооны ажил** | | | |
| 3.01 | Хөвөөг тэгшилж засах. Шаардлагатай газруудад дүүргэлт шинээр хийх. | м3 | 13.0 | Програмаас авсан хучилтын тоо хэмжээг үзэх. |
| 3.02 | Техникийн шаардлагад заасны дагуу ул хөрсийг индүүдэж нягтруулах | м2 | 176.3 | Хоёр талын 0.5 м өргөн хөвөөг нийт уртад нягтруулахаар тооцов. |
| 3.03 | Техникийн шаардлагад заасны дагуу тохирсон хөрсөөр далангийн дүүргэлт ухмалаас хийх /хөвөөний хамтаар/ | м3 | 0.0 | байхгүй |
| 3.04 | Техникийн шаардлагад заасны дагуу тохирсон хөрсөөр далангийн дүүргэлтийг карьераас хийх /хөвөөний хамтаар/ | м3 | 0.0 | байхгүй |
| | **4. Хучилтын ажил** | | | |
| 4.01 | Техникийн шаардлагад заасны дагуу зохистой найрлага бүхий хөлдөлтөөс хамгаалах үе хийх | м3 | 0.0 | байхгүй |
| 4.02 | Техникийн шаардлагад заасны дагуу зорчих хэсгийн L хашлага суурьлуулах | у/м | 336.5 | Зорчих хэсгийн хүрээ шугамны уртаас тооцож авав. |
